

ТАНИЛЦУУЛГА

Журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Зайлшгүй шааардлагаар мэргэжлийн (гэмтлийн) эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дагуу засал эмчилгээ (протез, ортопед)-г гадаад оронд хийлгэхэд түүний нэг удаагийн үнийг Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийг баримтлан олгож болно. Монгол Улсад хийдэг хиймэл эрхтэн, засал эмчилгээ (протез, ортопед)-ний жишиг үнийн жагсаалтыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан.

Энэхүү хуулийн заалтыг хэрэгжүүлэхээр Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/507, А/112 дугаар тушаалаар жишиг үнийн жагсаалт шинэчлэн баталж, тушаалыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Заавар батлах тухай” 2021 оны А/162 дугаар тушаалыг мөрдөж байна.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 14 дүгээр зүйлийн 14.10-т “Даатгуулагч төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэхтэй холбогдсон бусад харилцааг зохицуулсан журмыг Засгийн газар батална” гэж заасан. Энэхүү хуулийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Иймд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас даатгуулагч төлбөр авахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон төлбөрийг олгох, санхүүжүүлэхтэй холбогдсон бусад харилцааг зохицуулсан журмыг батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулав.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 6219 иргэн хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч байгаа бөгөөд үүнээс протез, ортопед хийлгэсэн хүн 4, түүний зардал 5.1 сая төгрөг (2022 онд протез ортопед хийлгэсэн хүн 9, түүний зардал 7.6 сая төгрөг) байна. 2023 онд хиймэл эрхтэн, засал эмчилгээний зардалд 120.5 сая төгрөг, 2024 онд 241.1 сая төгрөг тус тус төсөвлөсөн байна.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас 2023 оны 9 дүгээр сарын байдлаар сэргээн засах төв болон сувиллын тусламж, үйлчилгээг 1156 хүн, түүний зардал 741.8 сая төгрөг (2022 онд 2053 иргэнд 1.1 тэрбум төгрөг) зарцуулсан байна. 2023 онд 2,1 тэрбум төгрөг, 2024 онд 2.2 тэрбум төгрөг тус тус төсөвлөсөн байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2023 оны А/143, А/376 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас олгох протез, ортопедийн жишиг үнийг баталсан. Энэхүү тушаалаар нийт 29 төрлийн протез, ортопедийн төлбөрийг 15 сая хүртэлх төгрөгөөр үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас санхүүжүүлэхээр баталсан.

Журмын төсөлд даатгуулагч иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор төлбөр авахад бүрдүүлэх материалыг цахимаар бүрдүүлж болохоор, мөн нийгмийн даатгалын байгууллага өөрт байгаа мэдээллийг иргэдээс шаардахгүй байхаар тусгасан болно.

Энэхүү тогтоолын төсөл батлагдсанаар ажил олгогч, даатгуулагч хууль тогтоомжийг нэг мөр ойлгож мөрдөх ба тогтоолыг хэрэгжүүлэхэд улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт санхүүжилт шаардагдахгүй болно.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ